



МОНГОЛ  
АРДЫН НАМЫН  
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД МОНГОЛ АРДЫН  
НАМААС НЭР ДЭВШИГЧИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ**

Монгол Ардын Намын Бага хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, Улс төрийн намын тухай Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид Монгол Ардын Намаас нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг сайшаан дэмжсүгэй.

ДАРГА



Д.ДЭМБЭРЭЛ

ОРЛОГЧ ДАРГА



Н.УЧРАЛ

Б.ЖАРГАЛМАА

45

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2013 ОНЫ СОНГУУЛЬД  
МОНГОЛ АРДЫН НАМААС НЭР ДЭВШИГЧ БАДМААНЯМБУУГИЙН  
БАТ-ЭРДЭНИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**Уриа: Эвийг эрхэмлэнэ  
Зөвийг дэмжиэ**

Монгол Ардын Нам гишүүдийнхээ төдийгүй нийт ард түмний дунд “Эв нэгдлийн элчийг ард түмнээсээ тодруулъя” хэлэлцүүлэг өрнүүлж, олон түмний санаа бодлыг тодорхой асуудлуудаар тандан судлах замаар Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдүүлэх нэр дэвшигчээ тодруулж, миний нэрийг дэвшүүллээ. Миний бие үүнийг надад хүлээлгэж буй өндөр итгэл найдвар хэмээн хүлээн авч байна.

Ерөнхийлөгчид нэр дэвшсэний дараа улс төрийн зарим нам, иргэний нийгмийн олон байгууллага, түүний дотор ахмад, залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллагууд намайг дэмжин хамтран ажиллахаа илэрхийлсээр байгаад би урамтай байна. Улс орон, ард түмэн Ерөнхийлөгчөөсөө юу хүсч, хүлээж байгаа, энэ бүхнийг хийхэд Ерөнхийлөгчийн эрх мэдлийн хүрээ, хуулиар олгосон боломж, хувь хүний давуу талыг хэрхэн бүрэн ашиглаж болох талаар нийгмийн олон давхрагын янз бүрийн хүмүүстэй уулзаж санаа бодлоо солилцож, нягтлан тунгааж ажиллалаа.

Өнөөдөр манай улсад дэвжин дээшилж, болж бүтэж байгаа зүйл олон байгааг үгүйсгэх учиргүй. Үүний нөгөө талд цаг алдалгүй засч залруулан **зөв** болгох зүйл ч зэгсэн байна. Сайн нь ч, муу нь ч Монголчууд бидний хамтын ололт амжилт, хамтын алдаа дутагдал юм.

Ард түмний сэтгэл санааг илүү зовоож, улс орны хөгжил, хүн ардын амьдралд саад учруулж байгаа **буруу** зүйлүүд гэвэл:

-Улс төрийн талцал хуваагдал даамжирч, үндэсний эв нэгдлийг хангах зарчмын хэрэгжилт өнөөгийн шаардлагаас хоцорч, ард түмэн үүнд эмзэглэж байгаа;

-Монгол Улсын газар нутгийн бүрэн бүтэн байдал, эх орныхоо онгон сайхан байгальд хайр гамгүй хандан доройтуулж байгаа;

-Цалин тэтгэвэр өсөхгүй атлаа өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, тариф өссөөр байгаа;

-“Оюутолгой” зэрэг томоохон төслөөс Монгол Улсад ногдох хувь багасаж, үүний улмаас ард түмэн баялагийнхаа үр шимийг жигд, хүртээмжтэй хүртэж чадахгүй байгаа;

-Хуулийг хэрэгжүүлэх шүүх, хууль, хяналтын байгууллагууд хүн бүрт тэгш шударга үйлчлэхгүй байгаа;

202 216

-Төрийн албан хаагчдын төрд тууштай ажиллах баталгаа үгүй болж байна.

Энэ бүгдийг зөв болгохын төлөө зүтгэх нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдох хүний эрхэм үүрэг хэмээн ухаарч, “Эвийг эрхэмлэнэ, Зөвийг дэмжинэ” уриатайгаар сонгуульд оролцож байна.

“Эх орон бол газар нутаг, ард түмэн хоёр юм. Эх орноо бүрэн бүтэн, ард түмнээ амгалан жаргалантай амьдруулах нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрхэм зорилго, улс орон хөгжин мандахын үндэс юм” гэсэн өөрийн итгэл үнэмшилдээ тулгуурлан, улс үндэстнийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, ард түмнийхээ ахуй амьдралыг сайжруулан, эх орныхоо хөгжил дэвшлийг хурдасгахад чиглэсэн Мөрийн хөтөлбөрөө өргөн олон сонгогчиддоо толилуулж байна.

### **Нэг.Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх нь Ерөнхийлөгчийн эрхэм үүрэг мөн.**

- Улс төрийн тогтвортой байдал, ард түмний хүсэл сонирхол, эв нэгдлийг хангах үүднээс улс төрийн хүчнүүдийн хоорондын саналын зөрүү, маргааныг зөвхөн хуулийн хүрээнд харилцан ойлголцол, зөвшилцлөөр шийдвэрлэдэг байх зарчмыг төрийн удирдлагын бүх түвшинд удирдамж болгон ажиллана.
- Улс төр, нийгмийн амьдралын бүхий л хүрээнд газар аваад байгаа үгүйсгэх, гүтгэх гажуудлыг залруулан, бие биенийхээ ололт, амжилтыг хүлээн зөвшөөрч, дэмжин урамшуулж, хамтран ажилладаг үзэл санааг төлөвшүүлнэ.
- Шударга байх, шударга амьдрах, шударга ёсыг тогтоох чиглэлээр хүн амын дунд соён гэгээрүүлэх ажлыг улс орон даяар явуулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- Хүүхэд, залуучуудыг бага балчраас нь эх орон, аугаа түүх, ард түмнээрээ бахархдаг, монгол ёс жудгаа дээдэлдэг, үндэсний уламжлалт зан заншлаа дагадаг, мэргэжлээ зөв сонгодог, халуун дулаан сэтгэлтэй болгон хүмүүжүүлэх зорилтыг боловсролын агуулгад тусган, ирээдүйн иргэдийг бэлтгэх ажилд анхаарал хандуулна.
- Хэвлэл мэдээллийн бие даасан, хараат бус байдлыг хангана. Нийгэмд тогтвортой байдал бий болгох, хүмүүсийн харилцан ойлголцол бие биендээ хүндэтгэл найртай хандах үзлийг төлөвшүүлэхэд ёс зүйтэй сэтгүүл зүй шийдвэрлэх үүрэгтэй гэж үзэн бүх талаар дэмжинэ.
- Үндсэн хуулиар тогтоосон засаглал хуваарилалтын зааг ялгааг хатуу баримталж, хэрэгжилтийг хангуулан, хууль, ёс зүйг дээдэлнэ.

- 125 217
- Төрөөс төрийн болон төрийн бус байгууллага, төрийн өмчийн болон хувийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагад ялгаваргүй хандах үзлийг нийгэмд төлөвшүүлнэ.

**Хоёр. Ард түмнээ сэтгэл амгалан, тэгш дүүрэн амьдралд хөтлөх нь Ерөнхийлөгчийн эрхэм үүрэг мөн.**

- Баялгийн хуваарилалтыг тэгш, шударга болгоно.
- Эх орон, ард иргэдээ өрийн хүлээсэнд оруулахгүй байх бүх талын боломжийг дайчлан ажиллана.
- Хүн амын өргөн хэрэглээний гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн зохиомол хөөрөгдөл гаргуулахгүй байхад хяналт тавьж, иргэдийнхээ амьжиргааны түвшинг бууруулахгүй байх, эрсдэлээс хамгаалах бодлого хэрэгжүүлнэ.
- Мал аж ахуй, газар тариаланг аливаа эрсдэлээс хамгаалах, малчид, тариаланчид, ногоочдыг дэмжих бодлого явуулна.
- Багш, эмчийн ажлын нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх чиглэлээр шаардлагатай хууль тогтоомж санаачилан ажиллана. ✓
- Оюутнуудын сургалтын төлбөр, хөнгөлөлтийн асуудлыг суралцагчдын сурлагын амжилттай уялдуулан шийдвэрлэх боломжийг судлана. ✓
- Цэрэг дайчид, төрийн тусгай албадад ажиллагсдын ахуй байдлыг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, цэрэгт иргэний боловсрол олгох, эх орны бүтээн байгуулалтад идэвхитэй оролцуулах арга, боломжийг судлан хэрэгжүүлнэ.
- Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын төвийн оюутан залууст эх орноо батлан хамгаалах боловсрол олгож, цэргийн алба хаасанд тооцох боломжийг судлан шийдвэрлэнэ.
- Ядуу өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэх замаар нийгмийн дундаж давхрааг өргөжүүлэхийг бодлогоор дэмжинэ.
- Ахмад настныг төрийн ивээлд байлгах бодлогыг үргэлжлүүлэх, хүүхэд нялхсыг төрийн хамгаалалтад байлгах тухай хууль санаачилна.
- Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн ахуй амьжиргааг дэмжих, тэдэнд туслах тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

- 48
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн зүгээс эергээр хүлээн авах хүмүүнлэг хандлагыг бий болгон, тэднийг нийгмийн үйл хэрэгт идэвхитэй оролцуулах бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
  - Нийтийн биеийн тамирыг хүн амыг чийрэгжүүлэх арга, спортыг бие хүний авъяас чадварыг нээн хөгжүүлэх боломж, Монгол Улсаа дэлхийд таниулан сурталчилах гарц гэж үзэн тал бүрээр дэмжинэ.
  - Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, олон улсын жишигт ойртуулна.
  - Нийслэл хотод нийтийн тээврийн автобус, троллейбусаар иргэдийн зорчих төлбөр, үйлчилгээг тэгш хүртээмжтэй болгох асуудлыг судалж шийдвэрлэнэ.
  - Нийтээрээ цэвэр цэмцгэр орчинд амьдрах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Соёлтой амьдралын хууль” санаачилж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
  - Хүүхдийн ясли, цэцэрлэг, сургууль, эмнэлгийн барилга байгууламжийг одоогийн шаардлагыг хангах хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.
  - Нийслэл хотыг утаагүй болгох, гэр хорооллыг барилгажуулах, соёлтой үйлчилгээ бүхий, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл бүрдсэн орчин үеийн хот болгох бодлогыг дэмжинэ.

**Гурав.Эдийн засгийн хөгжлийн зөв бодлогыг дэмжих нь  
Ерөнхийлөгчийн эрхэм үүрэг мөн.**

- Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчноо хамгаалах бодлогыг тэнцвэртэй байлгахад бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлнэ.
- Уул уурхай, материал баялагт шүтсэн өрөөсгөл эдийн засгийг уламжлалт мал аж ахуй, үндэсний үйлдвэрлэл, мэдлэгт суурилсан, байгальд ээлтэй эдийн засагтай хослуулах зохистой бодлогыг дэмжинэ.
- Төрийн оролцоотой малчдын хувь нийлүүлсэн хоршоог баг, суманд байгуулан бэхжүүлж, мал аж ахуйн түүхий эдийг худалдан авах, анхан шатны боловсруулалт хийх, савлах, борлуулах, үндэсний үйлдвэрүүдийг түүхий эдээр шат дамжлагагүй хангах улсын хэмжээний сүлжээ байгуулахыг дэмжинэ.
- Боловсрол, шинжлэх ухааныг нийгмийн тэргүүлэх чиглэл болгон, монгол эрдэмтдийн шинэ бүтээл туурвилын үр дүнг үйлдвэрлэл, амьдралд

2023 49

хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж, урамшууллын тогтолцоо бий болгоно.

- Эрчим хүч, шатахууны хараат байдлыг багасгах, үнийг зохистой хэмжээнд барих зорилгоор газрын тос боловсруулах үндэсний үйлдвэр байгуулахыг чухалд үзнэ.
- Жижиг, дунд үйлдвэр, хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр орлогын хуваарилалт, дахин хуваарилалт, татварын тогтолцоог боловсронгуй болгох бодлого явуулна.
- Баялаг бүтээгчдийг бүх талаар дэмжинэ.

**Дөрөв.Газар нутаг, онгон байгалиа хайрлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлж, эх орныхоо баялагийн үр шимийг ард түмэндээ тэгш, шударга хүртээх нь Ерөнхийлөгчийн эрхэм үүрэг мөн.**

- Улс орноо хөгжүүлэх нэгдсэн, урт хугацааны, тогтвортой “ногоон” эдийн засгийн бодлоготой болох асуудлыг эрх зүйн хувьд баталгаажуулна.
- Эх байгалиа хайрлан хамгаалах чиглэлээр гарч буй иргэдийн бүхий л үүсгэл санаачилгыг дэмжинэ.
- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа иргэний нийгэм, ТББ-ын төлөөллийг оролцуулсан “Ногоон эдийн засаг” Үндэсний хороог Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэд байгуулан, үйл ажиллагааг нь бүх нийтийн хөдөлгөөн болгон ернүүлнэ.
- Ашигт малтмалын нийт лицензийг дахин шалган магадлаж, зөвхөн улс, орон нутгийн хөгжлийн эрх ашигт нийцсэн орд газруудыг ашиглах эрх зүйн орчин бий болгож, төрөөс хатуу хяналт тавьж хэвшүүлнэ.
- Эрдэс баялагийг түүхийгээр нь бус боловсруулалт хийж бүтээгдэхүүн болгон гадагш гаргах бодлогыг дэмжинэ.
- Үндэсний баялаг, ашигт малтмалыг судалгаа тооцоотой, үндэслэл төлөвлөлттэй ашиглан, хойч үедээ өвлүүлэн үлдээх бодлогыг баримтална.
- Байгалийн баялаг, ашигт малтмалын салбарын компаниудыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр ажиллах эрх зүйн орчин бүрдүүлэх бодлого баримтлана.
- Ашигт малтмалын орд газруудыг ард түмэнд өгөөжтэй, байгаль орчинд ээлтэй байх зарчмаар ашиглах бодлогыг дэмжинэ.

- 122  
50
- Эрдэс баялагийн салбарын эрх зүйн орчныг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлнэ.
  - Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг харилцан ашигтай, тэнцвэртэй байх нөхцөлөөр сайжруулна.

**Тав.Хууль, шүүхийг хүн бүрт тэгш, шударга үйлчилдэг байлгах нь иргэдээ хайрлах Ерөнхийлөгчийн эрхэм үүрэг мөн.**

- Иргэдээ аюулгүй, амгалан тайван орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд анхаарлаа хандуулна.
- Шударга шүүхийг төлөвшүүлэх ажлыг бүх талаар дэмжин, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүхэд мэргэжлийн өндөр ур чадвартай, ёс жудагтай, шударга хүмүүс ажилладаг байх зарчмыг баримтлана.
- Дэг журамгүй байдал, хүн амыг айдаст автуулсан аливаа сөрөг үзэгдэлтэй хийх тэмцлийг эрчимжүүлнэ.
- Архидалттай тэмцэх ажлыг бүх нийтийн үйлс болгож, амьдралын архигүй орчныг шинээр бий болгох эрх зүйн үндэс бүрдүүлнэ.
- Хүн амын дунд дургүйцэл, бухимдал үүсгэж буй асуудал, хүчин зүйлүүдийн судалгаа гаргаж, хүнийг сэтгэл санааны дарамтад орохоос сэргийлэх нөхцлүүдийг бүрдүүлэх арга хэмжээ авна.
- Авилгатай шийдвэртэй тэмцэнэ, авилгыг арилгахад ард иргэдийг идэвх санаачилгатай оролцдог хөшүүргийг бий болгоно.

**Зургаа.Төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн үйлчилгээг ард иргэддээ шударга, тэгш, чанартай хүргэх нь Ерөнхийлөгчийн эрхэм үүрэг мөн.**

- Төрийн албаны нэр хүндийг өргөж, төрийн албанд ажиллагсдын эрх ашгийг хамгаалах, тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- Төрийн албыг мэргэжлийн чадвар, дадлага сайтай, иргэдэд хүндэтгэлтэй ханддаг, ёс зүйн зөв төлөвшилтэй ажилтнуудаар бэхжүүлэх бодлогыг дэмжинэ.
- Ерөнхийлөгчийн хууль ёсны бүрэн эрхийн дагуу төрийн өндөр албан тушаалтныг санал болгон нэр дэвшүүлэх, зөвшилцөхдөө гагцхүү хууль, шударга зарчмыг баримтлана.

- 449  
51
- Төрийн албан дахь авилга, хүнд суртлыг арилгах тэмцлийг бүх талаар дэмжинэ.

**Долоо.Гадаад харилцааг тэнцвэртэй, найрсаг байлгах нь  
Ерөнхийлөгчийн эрхэм үүрэг мөн.**

- Монгол Улсын энхийг эрхэмлэсэн гадаад бодлогыг үргэлжлүүлэн, төрийн бодлогын залгамж чанарыг ханган ажиллана.
- Дэлхийн хамтын нийгэмлэгийн дунд Монгол Улсын эзлэх байр суурь, нэр хүндийг улам бэхжүүлнэ.
- Хөрш орнуудын харилцааг гадаад бодлогын тэнцвэртэй байдлыг хадгалах гол хүчин зүйл гэж үзэж, ОХУ, БНХАУ-тай адил тэгш, стратегийн түншлэлийн түвшинд хамтарч ажиллана.
- “Гурав дахь хөрш” орнуудтай хамтын ажиллагааны түншлэлийг улам хөгжүүлнэ.
- Төрийн гадаад харилцаанд нэг санаа, нэгдмэл бодлого баримтлах чиг шугамыг гол зарчим болгон, чанд мөрдүүлнэ.
- Гадаадад ажиллаж, амьдарч, сурч буй иргэдийн эрх ашгийг хамгаална. Нарийн мэргэжил, өндөр чадвар эзэмшсэн иргэдийг эх орондоо ирж ажиллах таатай нөхцлийг бүрдүүлнэ.

**Найм.Ардчиллыг бэхжүүлэх, үндэсний онцлогоо дээдлэх нь  
Ерөнхийлөгчийн эрхэм үүрэг мөн.**

- Ардчилал бол нэг нам хүчин, бүлэг, хэсгийн өмч биш. Ардчиллын үзэл санаа үнэт зүйлсийг нийгмийн амьдралын бүхий л хүрээнд баттайгаар дэлгэрүүлэн бэхжүүлэхийг Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгоно.
- Монгол хүний эв эеийг хичээдэг хүлээцтэй уужуу тайван ухаан, бие биенээ хайрлан элгэмсдэг халуун сэтгэл, шударга үнэнийг дээдэлдэг ёс жудгийг хөхиүлэн дэлгэрүүлнэ.
- Монголчуудынхаа эх оронч сэтгэлгээ, эх орноо хайрлах, эх орноороо бахархах үзлийг сэргээн бадруулахыг эрхэм чухалд үзнэ.

х                    х                    х

Миний бие Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох Мөрийн хөтөлбөрийнхөө хураангуйг Та бүхэндээ танилцууллаа.



Монгол Улсын Ерөнхийлөгч бол Монгол хэмээх их айлын өрхийн тэргүүн юм. Энэ айлд ахмад настан, хүүхэд багачууд, идэр залуус, оюутан сурагч, малчин тариачин, бизнес эрхлэгч, сэхээтэн албан хаагч, эрдэмтэн мэргэд, эмч багш, цэрэг цагдаа зэрэг бүгд бий. Хүний эцэг үр хүүхдээ алагчилдаггүй шиг Монгол Улсын Ерөнхийлөгч иргэдээ алагчлах учиргүй. Иймээс би ард түмнийхээ эс бүхэнд тэгш сэтгэлээр хандан хайрлана.

Монгол хэмээх энэ их айлд бас төлөвшил хүмүүжил сайтай, ёс жудагтай, сахилга журамтай хэсэг, эрх танхи, дураараа авирлах зантай, үзэл бодлын зөрүүтэй хэсэг ч бий. Хүний эцэг хүүхдүүдийнхээ болж байгааг нь дэмжин урамшуулж, болохгүйг нь зэмлэж тэгшитгэдгийн адил энэ их айлын олон иргэн, нам, бүлэг, хэсгийн сонирхол, үйл ажиллагааны зөвийг нь дэмжиж, зөрүү бурууг нь засаж залруулна, загнана бас аргадна.

Монгол Улсын Ерөнхийлөгчид хуулиар олгосон бүрэн эрх бий бөгөөд тэр эрхээ хэрхэн хэрэгжүүлэх нь тухайн Ерөнхийлөгчийн хувь хүний онцлог, нэр хүнд, ёс суртахууны төлөв байдал, мэдлэг чадвар, бусдыг засан залах арга ухаан, эв дүй, дагуулан манлайлах үлгэр дууриалал, далайцаас хамаарна. Би хөтөлбөрөө хэрэгжүүлэхдээ залуучуудад найдаж, ахмад үеийнхнээс арга ухаан авч, өөрийн үеийнхэнтэй зөвлөж зөвшилцөж ажиллана.

Миний бие эвийг эрхэмлэнэ, зөвийг дэмжинэ.

2013.05.15

Улаанбаатар хот